

БОЛОВСГОЛ, МИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМНЫ ТӨРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Х.БАТЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 2 ДУГААР ХАВСРАЛТ  
XIII.1.1.337 "ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА ХУДАЛДАН АВАХ /УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН 40 ДҮГЭЭР ХОРОО" ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХЫН  
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 01


Улаанбаатар хот


1	Үндэслэл	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт XIII.1.1.337 Цэцэрлэгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 40 дүгээр хороо/ төсөл арга хэмжээ
2	Худалдан авах байршил	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 40 дүгээр хороо
3	Зориулалт, хүчин чадал	- 200 ортой цэцэрлэгийн барилга, 840м2-аас багагүй талбайтай
4	Барилгын үндэс, бүтэц, материал	- Төмөр бетон каркас
5	Барилгын суурь	- Төмөр бетон суурьтай байх
6	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	- Дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон - Цахилгааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон - Цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон
7	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм/ БНБД21.02.02 / хангах - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД21-01-02/ норм дүрэм хангах - Утаа мэдрэгч, галын дохиололтой байх
8	Анги, танхим, тоног төхөөрөмж	<b>Барилга, байгууламжид зайлшгүй байвал зохих өрөө тасалгаа:</b> 1. Бүлгийн өрөө /Иж бүрэн тавилга, хүүхдийн сандал, ширээ, гудас, хөнжил, багшийн ширээ сандал, бичгийн шүүгээ, дэвсгэр/шал/, насны ангиллаар сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, хөгжмийн зэмсэг, биен тамирын хичээлийн хэрэглэгдэхүүн зэрэг нь стандартад нийцсэн, хүүхдийн иж бүрэн тохижилттой ариун цэврийн өрөөтэй, бүлэг тус бүрд хүчин чадалд таарсан тоо хэмжээгээр байна. Мөн Багшийн суурин компьютер i7 үзүүлэлтээс багагүй, 3 үйлдэлт принтер бүлэг тус бүрд байх/ 2. Хүлээн авах өрөө /Сандал, ширээ/ 3. Хувцас солих өрөө /Хүчин чадалд тохирсон хүүхдийн хувцасны шүүгээ, санал/ 4. Ариун цэврийн өрөө /Багш ажилчдын зориулалттай/ 5. Захиргааны өрөө /Эрхлэгч ширээ, хурлын угтвар ширээ, сандал, бичгийн шүүгээ, суурин компьютер i7 үзүүлэлтээс багагүй, 3 үйлдэлт принтер байх / 6. Эмчийн өрөө /Стандарт хангасан тавилга, тоног төхөөрөмжтэй байна/ 7. Тусгаарлах өрөө /Стандарт хангасан тавилга, тоног


		<p>төхөөрөмжтэй байна/</p> <p>8. Багш ажилчдын өрөө /Хурлын ширээ, сандал, ухаалга хичээлийн самбар, бичгийн шүүгээ, тавиур, хувцасны шүүгээ/</p> <p>9. Угаалга, индүүдлэг, хатаалгын өрөө /Бүрэн автомат 13кг дээш хүчин чадалтай угаалгын машин-2 ширхэг, индүүний суурь-2ш, уурын индүү-2ш байна.</p> <p>10. Гал тогоо хүчин чадалд тохирсон /Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандарт хангасан тавилга, тоног төхөөрөмжтэй байна/</p> <p>11. Агуулах хүчин чадалд тохирсон /Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандарт хангасан тавилга, тоног төхөөрөмжтэй байна/</p> <p>12. Анги, танхим, бүлэг тус бүрд байх шаардлагатай тоног төхөөрөмжийг стандартад нийцүүлсэн байна.</p>
9	Онцгой нөхцөл	<p><b>Барилга байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багш ажилчдын ариун цэвэр, амралтын өрөөтэй байх;</li> <li>- Бүлгийн өрөөнүүд нарны гэрэл шууд тусгалтай байх;</li> <li>- Нэг ангид 25-30 хүүхэд багтах хэмжээтэй байх;</li> <li>- Хүүхдийн хувцас солих өрөө, үүдний өрөө, ариун цэврийн өрөө зэргийг тусад нь төлөвлөсөн байх;</li> <li>- Барилга байгууламж ашиглалтын явцад үүссэн аливаа гэмтэлгүй, шаардлага хангахуйц байх;</li> </ul> <p><b>Гадна талбай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулдсан байх;</li> <li>- Барилгын аврах гарц норм дүрмийн дагуу байх;</li> <li>- Цэцэрлэгийн гадна жагсаалын талбайтай байх</li> </ul> <p><b>Инженерийн шугам сүлжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ангиудын агааржуулалт, салхивчийн нэгдсэн систем норм нормативын дагуу байх;</li> <li>- Бүлгийн ариун цэврийн өрөөнд насны ангилалд тохирсон гар угаалтуур, суултуур бусад тоноглолтой эвдрэл гэмтэлгүй байх;</li> <li>- Цэвэрлэгээ үйлчилгээнд зориулсан тосгууртай эвдрэл гэмтэлгүй байх;</li> <li>- Розетка / ХТ / норм стандарт хангасан байх;</li> <li>- Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлага хангасан байх;</li> <li>- Гадна талбай болон дотор бүлгийн өрөөнүүд камертай, 14 хоногоос багагүй хугацаанд бичлэг хадгалдаг байх;</li> </ul>
10	Төслийн иж бүрдэл	<p><b>Баримт бичгийн иж бүрдэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Инженер геологийн дүгнэлт</li> <li>- Онцгой байдлын дүгнэлт</li> <li>- Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт /</li> </ul> <p><b>Зургийн төслийн иж бүрдэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эскиз / батлагдсан /</li> <li>- Ажлын зураг / батлагдсан /</li> <li>- ЕТ - Ерөнхий төлөвлөгөө</li> <li>- БА - Барилга архитектур</li> <li>- ТХ - Технологийн зураглал</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- ББ - Барилгын бүтэц /Бүтээцийн тооцооны хамт/</li> <li>- ХАС - Халаалт агаар салхивч</li> <li>- ЦБУ - Цэвэр бохир ус</li> <li>- ДТ - Дотор гэрэлтүүлэг</li> <li>- ХТ - Хүчит төхөөрөмж</li> <li>- ХД - Холбоо дохиолол</li> <li>- ГД - Гадна дулаан хангамж</li> <li>- УХАТ - Ус хангамж ариутгах татуурга</li> <li>- ГЦ - Гадна цахилгаан хангамж</li> <li>- ГХ - Гадна холбоо дохиолол</li> </ul>
11	Архитектур	<b>Ерөнхий төлөвлөгөө:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу норм дүрэм хангасан байх;</li> </ul>
12	Дараах БНБД хангасан байх	<b>Норм нормативууд:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм / БНБД 30-01-04 /</li> <li>- Олон нийт иргэний барилгын норм дүрэм /БНБД 31.03.03/</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм / БНБД 3.01-06-90 /</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шаттай байх / MNS 6056:2003, 6055:2009 /</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах</li> <li>- Барилгын төсөв зохиох дүрэм / БНБД81-95-12 /</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм хангасан байна.</li> </ul>
13	Төлбөр тооцоо	Нийлүүлэгч тал цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбоо дохиолол болон бусад байгууллагад төлбөрийн үлдэгдэлгүй байна.
14	Үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаар барилгад үнэлгээ хийлгэж баталгаажуулсан байх;</li> <li>- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтах;</li> </ul>

ХЯНАСАН:

БШУЯ-НЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
 ГАЗРЫН ДАРГА  / Б.БАТЦЭЦЭГ /

БШУЯ-НЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
 ДАРГА  / Х.ТАМИРАА /

БШУЯ-НЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
 АХЛАХ ШИНЖЭЭЧ  / Ч.БАТБОЛД /  
 БОЛОВСРУУЛСАН:

БШУЯ-НЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  / Т.МӨНГӨНТУЛГА /

